



Авьяас билгийг уул ус нь хайрладаг ажгуу...

Дуутай танилцсан түүх...

Хөгжмийн далайгаар аялсан нь...

*Төв телевизийн студийн хойморт
заларсан нь...*

*Хилийн дээсэн дээгүүр солонгорсон
"зүрхний эрэл" ...*

Талын салхи үнэртсэн бүтээлүүд...

Дуу ХӨГЖИМ

Авьяас билгийн зургаан хэлхээ

- Залуу хөгжмийн зохиолч Цэцэн-Цогт

2

Залуу хөгжмийн зохиолч Цэцэн-Цогтын тухай өгүүлэх “Авьяас билгийн зургаан хэлхээ” тэмдэглэл

Авьяас билгийг уул ус нь хайрладаг ажгуу...

"Мөхрүү мөхрүү шорон хад аа хө..." гэж эхэлдэг энэхүү Баарин ардын дууны яруу тунгалаг аялгуу дуурсан уянгалахуйд Шар мөрний тогтуун урсгалд тольдон наадах хөх тэнгэр, хөвөн цагаан үүлс, хөвөө хязгааргүй үргэлжлэх ногоон толгодын дунд цайвалзан харагдах сувдан гэрүүд... гээд байгаль эхийн тансаг сайхан зураг өөрийн эрхгүй нүднээ тодордог юм.



Баарин хошууны тунгалаг сайхан хавар цагийн намуухан үдэш, өдөржин нар ээсэн зөөлөн ширгэн дээр суугаад ирж буй цагийн урин дулааныг, басхүү сэрүүн тунгалгийг зэргэд мэдрэхүйд хэлж боломгүй нэгэн аз жаргалд умбан, уяран догдолдог юм. Энэ сайхан нутгаас ямар олон яруу найрагч, зохиолч, дуучин, морьтон баатрууд төрөө вэ? Өнөөдөр бас нэгэн хөгжмийн зохиолч тодорчээ. Авьяас билэгтнийг төрүүлдэг нь Баарин нутгийн үзэсгэлэнт уул ус гэхээс өөр юу гэх билээ л....

Дуутай танилцсан түүх...

1969 оны дүн өвөл Улаан хад хотын Баарин баруун хошууны малчин Сээдэннямын гэрт нэгэн хөвгүүн төрсөн нь хожмын хөгжмийн зохиолч Цэцэн-Цогт билээ. Тэр үед аж амьдрал ядуу зүдүү хэдий ч Цэцэн-Цогт төрсөн голомтынхоо халуун дулаанд, аав ээжийнхээ энэрэл хайранд юугаар ч дуталгүй өсөж торнисон юм. Түүний багад аав нь хөгжилтэй хошин яриа дэлгэж, ээж нь яруу сайхан дуугаа дуулдаг байв. Бяцхан хөвүүн ээжийгээ дагаж дуулах дуртай. Бас “Шидэт хайрцаг” мэт санагддаг өнгө будаг нь элэгдэж хуучирсан радиогоо өвөр дээрээ тавиад суухад урам зориг нь сэргэж, ухаан санаа нь тэлдэг байлаа.

Бяцхан хөвүүний заяамал авьяас билгийг тэрхүү “Шидэт хайрцаг” нь ундармал булгийн усаар

ундаалсан үр хөврөл мэт соёолон ургуулсан гэлтэй. Тэрээр дунд сургуульд сурч байхдаа уянгат цээл хоолойгоороо багш сурагчдыг бишрүүлдэг байв. Дабаны 1-р дунд сургуулийн дуу хөгжмийн багш Отгонбаярын сургаал дор дуу хөгжмийн анхны мэдлэг эзэмшив.

Цэцэн-Цогт алдарт дуучин Лхасүрэн, Дэдмаа, Мү-лань нарыг шүтэн биширч, хэзээ нэгэн цагт тэдний адил урлагийн ариун тайзнаа нижигнэсэн алга ташилтын дор төгс жавхаатай зогсохсон гэж мөрөөддөг байв.



1988 онд, Цэцэн-Цогт ӨМБИС-ийн дуу хөгжмийн салбарт дууны мэргэжлээр сурахаар Баарин нутгаасаа мордсон юм. Тэр үед хөдөөгийн хөвүүн анх удаа галт тэргээр зорчиж, анх удаа төгөлдөр хуур харсан гэдэг. Цэцэн-Цогт сургуулиа төгсөхийн өмнөхөн Санхүү, Эдийн засгийн дээд сургуулийн оюутан Жинь-Лүнтэй хамтран "23 насны зогсоол" дуугаа зохиосон нь Хөх-Хотын оюутан залуусын дунд ихэд дэлгэрч, бүр дуулах дуртай дуу нь болсон байлаа.

1992 онд сургуулиа дүүргэж, сургуульдаа багшлах болсон Цэцэн-Цогт Өвөр Монголын радиогийн Монгол утга урлагийн хэлтсийн ажилтан Шинжилттэй зориглон уулзаж, "23 насны зогсоол" дуугаа радиогоор нэвтрүүлэх хүсэлт тавьжээ. Анх уулзаж байгаа хэдий ч, халуун сэтгэлт Шинжилт багш түүнийг ихэд тоож, "23 насны зогсоол" дууг нь "Долоо хоног тутмын нэг дуу" нэвтрүүлгээрээ хоёр долоо хоногийн турш нэвтрүүлжээ. Хожим энэ дуу нь 1993 оны цагаан сарын үдэшлэгийн гоцлол дуугаар сонгогдож, дараа нь Өвөр Монголын телевиз "Хайрын зогсоол" нэрээр сольж, Цэцэн-Цогтод MTV бичиж өгсөн байна.



Хөгжмийн далайгаар аялсан нь...

Нэн удалгүй дуу хөгжим Цэцэн-Цогтын өмнө юутай ч зүйрлэшгүй хязгаар хярхахгүй их далай болон тодорлоо. Хөгжим зохион бүтээх ур чадвараа улам дээшлүүлэх үүднээс тэрээр 1997 онд Хятадын Дуу Хөгжмийн Дээд Сургуульд элсэн суралцав. Тэр үед Али-Бабагийн эрдэнэсийн агуйд орчихсон юм шиг нүд гялбам эрдэнэсийг хараад тэсгэлгүй ихээр баярлан хөөрч, цаг хугацаатай өрсөн эрт эдүгээгийн дотоод гадаадын олон арван дуу хөгжмийн сор шимийг өлсөж цангасан мэт шунан амталж, хөгжмийн их далай руу умбан орлоо. Уйгагүй хөдөлмөр, мятаршгүй эрэл хайгуул

хийсний үр дүнд тэрээр тооны хувьслаас чанарын хувьсалд шилжиж, олон төрлийн дуу хөгжмийн шилдэг элементийг уураг тархиндаа шингээн авч байлаа. Чухам тэр л үед алсын алсад буй уугуул нутаг ус нь унтах нойронд нь байн байн зүүдлэгдэх болов.

Нэг өдөр хичээлийнхээ чөлөөгөөр хөгжмийн өрөөндөө тухлан сууж байтал тас хар төгөлдөр хуураас нь бүдэгхэн гэрэл туяарч харагдав. Тэрхүү зурвас гэрэл бургилан урсах горхи толгодын дундуур жирэлзэн урсах мэт Цэцэн-Цогтын хурууны аясаар төгөлдөр хуурын даруул дээгүүр догдолсон сэтгэлийн айзам хэмнэлийг нь илэрхийлэн бүжиж, эх нутгаа гэсэн энэрэл хайрын яруу тунгалаг хөгөөр уянгалан дуурслаа. Энэ бол "Хөх Монголын өндөрлөг" хэмээх шилдэг дуу төрсөн торгон агшин билээ. Энэ сайхан дууны шүлгийг яруу найрагч Ү.Начин зохиож, алдарт дуучин Дэдмаа дуулсан юм. Тэр цагаас хойш "Хөх Монголын өндөрлөг" дуу зон олны талархлыг хүлээсэн шилдэг дуу болсон юм. Энэ алдарт дуунаас хойш Цэцэн-Цогт ая дуу, найрал дуу, морин хуурын найрал хөгжим, кларнетийн гоцлол хөгжим гээд нийт 200 гаруй бүтээл туурвиад байна.



Төв телевизийн студийн хойморт заларсан нь...

2005 оны 5-р сарын 16-ны үдэш... "Алсад цэнхэрлэх уул толгод, Аяны хун шиг монгол гэрүүд, Аралт тэрэг нарыг борвидон хөврөхөд ээжийн минь төрх хараанд тодорно..." хэмээн алдарт дуучин Дэдмаа яруу эрдүү хоолойгоор дуулахад үзэгчид үе үе алга нижигнүүлэн ташиж байна.

Алмааз эрдэнэ лугаа том жижиг гэрлээр чимэглэсэн студийн хойморт монгол үндэсний дээлтэй Цэцэн-Цогт саатан сууж, алдарт дуучин Дэдмаа шавиараа Цэцэн-Цогтод цэцгийн



баглаа хүргүүлж, уран бүтээлийн үдэшлэг нь төгс амжилтад хүрэхийг хүсэж баяр хүргэв.

Дуучин Ян Хунжи "Мэлтэлзэн урсах Хөх мөрөн зүүн тийш одно..." хэмээн дуулж, үзэгчдийг "Гурван

улс” нэгэн цагт тулгын гурван чулуу шиг мандан бадарч байсан түүхийн эрин үед хүргэж, гуулин бүрээ мэт эр хүний хүчтэй хоолойгоороо Ян Хунжи "Гайхамшигт хасаг тэрэг"-ийг уянгалуулан дуулж, хүмүүсийн санаа сэтгэлийг дагуулан хөтлөсөөр үзэсгэлэнт сайхан тал нутагтаа авч ирэв.

74 настай дуучин Хү Сүнхуа Цэцэн-Цогтын шинэхэн бүтээл болох "Ажнай хүлэг"-гийг дуулж, хуран цугласан бүгдийг байлдан дагууллаа. "Тал нутагтайгаа болзсон минь" гэдэг дуугаараа хүмүүст танил болсон Чи Фэн эл дуугаа залуу эрийн жавхлантай хоолойгоор эгшиглүүлэн дуулахад танхим дүүрэн үзэгчид намуухан даган аялж байлаа.

Цог хийморь нь бадарсан төгөлдөр хуурч Чэнь Мань-чүнь "Монгол бүжгийн ая" болон алдарт "Серенада"-г хөгжимдөхөд төгөлдөр хуур болоод морин хуурын уялдаа холбоо нэг талаар он жилүүд ая хөгийн шатаар урсан өнгөрөх мэт, нөгөө талаар оюун санааны номин чавхдас дээгүүр уянгалан дуулах мэт хүмүүсийн сэтгэл зүрхэнд бууна. "Хөдөө нутгийн дуучдын хаан хар азрага" хэмээгдсэн дуучин Тэнгэр "Бурхан сэтгэлтэй ээж"-ийгээ уянгалуулахад, алсад дуурсах өнө эртний цуурай, уярч догдолсон сэтгэл, ойлон давалгаалах айзам цохилго нь энэрэл хайрын долгисыг нээж байлаа. Ийнхүү Цэцэн-Цогтын уран бүтээлийн үдэшлэг телевизийн дэлгэцнээс үзэгч олныг холдуулалгүй нэгэн үдшийг өнгөрөөсөн юм.

Хилийн дээсэн дээгүүр солонгорсон "зүрхний эрэл" ...

Хятад-Монгол хоёр орны найрсаг харилцаа соёл урлагийн салбарт жилээс жилд улам гүнзгийрч, хоёр орны урлагийнхан хамтран ажиллах өргөн боломж бүрдсэн билээ. Тал нутгийн дууч Цэцэн-Цогт цаг төрийнхөө хур буянаар хойд хөршийнхөө уран бүтээлчидтэй хамтран ажиллаж буйгаа “их аз” хэмээн хэлэх дуртай.



Хятад-Монгол хоёр орны хилийн дээсийг алслан солонгорсон "Зүрхний эрэл" дууны аяыг Цэцэн-Цогт зохиож, шүлгийг Өвөр Монголын одон телевизийн хөтлөгч Насан бичиж, дууг Монгол улсын нэрт дуучин Сэрчмаа дуулсан юм. Дуучин Сэрчмаа Цэцэн-Цогтын "Би тал нутагтайгаа болзоотой" цомгийн баярт хүрэлцэн ирж, "Зүрхний эрэл" дуугаа үзэгч олондоо өргөсөн барьсан. "Зүрхний эрэл" дуу бол хөгжмийн зохиолч Цэцэн-Цогт, дуучин Сэрчмаа, нэрт хөтлөгч Насан гурвын анхны хамтын уран бүтээл юм. Тэд одоо "Сэтгэлийн богд уул" нэртэй Барга нутгийн дууны бүтээл дээр хамтран ажиллаж байна.

Цэцэн-Цогт Монгол улсын "Зохиолын дууны хаан" агсан Давга-Доржийн "Цөнзүхий" шүлэгт ая хийж, Бээжинд байгаа бяцхан дуучин Нурма, Нар-Нааш хоёр дуулсан билээ. Энэ дууг хүүхэд багачууд дурлан дуулдаг төдийгүй хөгшид ч хүртэл өхөөрдөн сонсох дуртай.



Талын салхи үнэртсэн бүтээлүүд...

Цэцэн-Цогтын бүтээл бүрээс талын хөх салхи нь үнэртэх шиг болдог гэж хүмүүс хэлэх дуртай.

Тэрээр хатуу хөтүү амьдрал дундаас ихийг бүтээх зориг итгэл өвөрлөж, хөгжмийн уран бүтээлийн амаргүй замаар явсан он жилүүдэд төрсөн нутгийнхаа нөмгөн буурал уулс, нүдэн тунгалаг нууртайгаа тэнцэхүйц тэнгэрлэг аялгуу бүтээж, гэгээн мөрөөдлөө биелүүлсэн. Урлагийн хүний хүсэл мөрөөдөл биелсэн эсэхийг эх нутгийн нь уул усны савдаг, элэг нэгт ард түмэн нь хүлээн байж, ханилан байж үнэлэх учиртай. Чухам ингэж л учирлуулах гэж тал нутгийнхандаа хандаж "Би тал нутагтайгаа болзоотой" цомогоо өргөн барьсан буйзаа. Түүний энэ цомогт багтсан "Хөх Монголын өндөрлөг", "Би тал нутагтайгаа болзоотой", "Зүрхний эрэл", "Бурхан сэтгэлт ээж", "Зүрхнээс уяатай нутаг", "Сэнсэн бороо", "Хайрын хадаг", "Цөнзүхий" зэрэг олон бүтээлээс нь талын хөх салхи нь амттагддаг юм.



Цэцэн-Цогтын зохиол бүтээл бүр нь тал нутгийнхаа урлаг соёлд өнгө гэрэл, гүн утга агуулга нэмсээр авай. Тэр удалгүй тэнгэр баганадсан аварга том мод лугаа тал нутгийнхаа шимт хөрсөнд үндэс гүн сууж, навч намя нь үүл гижигдэн ургана гэдэгт тал нутгийнхан нь итгэж байна.

Хөгжмийн нотоор домгийн бороо шаагиулж

Хүн зоньхоо сэтгэлийн цангааг тайлж

Монгол хиймориороо тулгын галаа дүрэлзүүлж

Тал нутагтайгаа тэнгэрлэг аялгуугаараа болзсон Цэцэн-Цогтын уран бүтээлийн онгод аадар бороо шиг ширүүн байгаасай, арван тавны саран шиг гэрэлтэй байгаасай, адууны чимээтэй тал шигээ тэнүүн байгаасай, ангир хорвоо мянга мянган ээжтэйгээ мөнх байгаасай хэмээн ерөөгөөд эл тэмдэглэлээ жаргаая.

Төрийн 1-р зэргийн ая зохиогч Цэцэн-Цогт 1969 оны өвөл, Өвөр Монголын Улаан-хад хотын Байран баруун хошуунд төржээ. 1992 онд Өвөр Монголын Багшийн Их Сургуулийг дуу хөгжмийн мэргэжлээр дүүргээд дараа нь сургуульдаа багшийн алба хаасан байна. Тэрээр Хятадын дуу хөгжмийн дээд сургуульд 1997 он, 2000 онд тус тус мэргэжил дээшлүүлжээ. 2002 онд Төвийн үндэстний их сургуулийн дуу хөгжмийн дээд сургуульд элсэн суралцаж, 2005 онд ая зохиох мэргэжлийн магистр зэрэг хамгаалсан байна. 2006 онд Төвийн хөгжмийн дээд сургуульд доктурантаар суралцаж, Хятадын нэрт хөгжмийн зохиолч, профессор Тан Жень-пиний удирдлага дор дууны ая зохиох чиг хандлагаар суралцсан байна.

Тэрээр 2005 оны 5-р сарын 16-ны үдэш, Төв телевизийн Шь Житан студид бие даасан концертоо дүүрэн амжилттай хийж байсан бөгөөд тун саяхан бас "Би тал нутагтайгаа болзоотой" шинэ цомгоо шинэ жилийн шижигнэсэн бэлэг болон ард түмэндээ өргөн дэвшүүлжээ.

Цэцэн-Цогтын уран бүтээлийн "Би тал нутагтайгаа болзоотой" цомог нийтлэх үйл ажиллагааг Улаан-хад хотын намын хороо, засгийн газраас зохион байгуулсан байна. Энэхүү үйл ажиллагаа 2009



оны 1-р сарын 3-ний өдөр Бээжин хотын Жинь-дү Синь-юань зочид буудалд ёслол төгөлдөр болж өнгөрлөө.

Сайхан эгшиг нь сонорт хүрэх тоолонд сар шиг холоос нутаг үнэртдэг дууны нэгэн бол "Хөх монголын өндөрлөг" байгаа юм. Энэ дууг бүтээхэд Цэцэн-цогт ая зохион, Ө.Начин шүлэг бичиж, нэрт дуучин Дэдма дуулсан нь ёстой тулгын гурван чулууг тухлан тавьсан шиг тэнцэж, "Хөх монголын өндөрдөг"-ийн гал цог бадарч, хүн ардынхаа сэтгэлийг дулаацуулж чадсан билээ.



Нэг өдөр хичээлийнхээ чөлөөгөөр хөгжмийн өрөөндөө тухлан сууж байтал тас хар төгөлдөр хуураас нь бүдэгхэн гэрэл туяарч харагдав. Тэрхүү зурвас гэрэл бургилан урсах горхи толгодын дундуур жирэлзэн урсах мэт Цэцэн-Цогтын хурууны аясаар төгөлдөр хуурын даруул дээгүүр догдолсон сэтгэлийн айзам хэмнэлийг нь илэрхийлэн бүжиж, эх нутгаа гэсэн энэрэл хайрын яруу тунгалаг хөгөөр уянгалан дуурслаа.